*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ СҮХБААТРЫН УНДРАХЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Зам,тээврийн хөгжлийн яам
Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “ Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэх, үйл ажиллагааг нь зохицуулах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гадаад нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2. ЗТХЯ болон яамны харьяа байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны нэгжүүдийн дунд сургалт, семинар зохион байгуулах. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 1.3. Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн гадаад айлчлалаар хэлэлцэх асуудалд салбарын чиглэлээр санал хүргүүлж тусгуулах. | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ 1.4. Зам, тээврийн хөгжлийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэл хангах, албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Арга хэмжээ 1.5. Зам, тээврийн хөгжлийн сайдын БНХАУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах | 60 | 10 | 70 | 70 |
| 6. | Арга хэмжээ 1.6. Гадаад улстай хийх Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зэрэг хамтын ажиллагааны уулзалтуудтай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулах | 60 | 5 | 65 | 65 |
| **Зорилт 2. Гадаад улс, олон улсын байгууллагуудтай зам, тээврийн салбарын чиглэлээр байгуулах хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийг байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах, бүх талын дэмжлэг үзүүлнэ.** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Гадаад улс, олон улсын байгууллагуудтай хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бусад баримт бичгийг байгуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах | | | | |
| **Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Авлигийн эсрэг хуульд заасны дагуу 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг заасан хугацаанд нь гаргаж тайлагнах | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 3.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллах | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 3.3. Нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан тайлагнах | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ 3.4. Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээх | 60 | 10 | 70 | 70 |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1. Зам, тээврийн хөгжлийн яамны гадаад арга хэмжээний чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, төлөвлөгөөг Гадаад харилцааны яаманд хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 2. Зам, тээврийн хөгжлийн сайдын урилгаар ХБНГУ-ын Холбооны Цахим хөгжил, тээврийн сайд, Бундестагийн гишүүн, ноён Др. Фолькер Виссингийн 2024 оны 03 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийх албан ёсны айлчлал зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| **Дундаж оноо:** | | | | 65 | 69.5 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах анхаарах асуудлууд” сэдэвт сургалтад хамрагдав. | 0 | | |
| 2. | Арга хэмжээ 2. Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших | 100% | 10 | |
| **Дундаж оноо** | | | 10 | 7.5 |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |

| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
|---|---|---|---|
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. [illegible] | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. [illegible] | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. Харилцааны чадвар | 7 | |
| **Дундаж оноо** | | 7 | 7.0 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 8.0 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо | |
|---|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* | 69.5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* | 7.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* | 7.0 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* | 8.0 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* | 92.0 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 90 / 92.0 | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Төрийн захиргааны удирдлагын
Газрын Гадаад хамтын ажиллагааны
Хэлтсийн дарга .............................. /Б.Нямдаваа/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.06.

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Төрийн захиргааны удирдлагын
Газрын, Гадаад хамтын ажиллагааны
Хэлтсийн ахлах шинжээч .............................. /С.Ундрах /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12...
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

.......................................... ...................................... /.................................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.18 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

.......................................... ...................................... /.................................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.28 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

.......................................... ...................................... /.................................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*

9024070512 5919487 СБТ-5-257890

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ СҮХБААТАРЫН УНДРАХЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт Нэг. " Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэх, үйл ажиллагаагаа нь зохицуулах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гадаад нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | Хэрэгжилтийн хувь | 2023 оны гадаад, арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллан батлуулж, 95% хэрэгжүүлсэн. | 2024 оны гадаад арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллана, төлөвлөгөөний хэрэгжилт 40-өөс доошгүй хувь байна | Зам, тээврийн хөгжлийн яамны яамны 2023 оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт нэгтгэн гаргасан.<br>-2024 оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөө гаргах бэлтгэл ажлын хүрээнд харьяа байгууллага болон холбогдох газруудаас санал авч төсөл бэлтгэн, төлөвлөгөөг батлуулахад бэлтгэн ажиллав. | I улирал | |
| 2. | Арга хэмжээ 1.2. ЗТХЯ болон яамны харьяа байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны нэгжүүдийн дунд сургалт, семинар зохион байгуулах | Сургалт, семинар зохион байгуулагдсан байна. | 2023 оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд туссан ч бусад арга хэмжээтэй хугацаа давхцсан тул хойшилсон. | ЗТХЯ болон яамны харьяа байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны нэгжүүдийн дунд сургалт, семинар зохион байгуулах | Монгол Улсын Зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй гадаад харилцаа, хамтын ажиллагаанд нэгдмэл бодлого чиглэл баримтлах, гадаад арга хэмжээний үйл ажиллагааг харилцан уялдаатай төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалтаар | I- II улирал | |

37

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангах зорилгоор "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид болон харьяа байгууллагуудын гадаад харилцааны асуудал хариуцсан албан хаагчдын сургалт, семинар"-ыг 2024 оны 05 сарын 07-ны өдрийн 08.30-11.30 цаг хүртэл Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот хурлын зааланд зохион байгуулав.<br>Сургалтад Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газрын дэд захирал Г.Батбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД С.Батболд, БТГ-ын дарга Б.Болор-эрдэнэ оролцож илтгэл тавьж, мэдээ мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Сургалтад гадаад хамтын ажиллагааны хэлтсийн 4 албан хаагч, харьяа 8 байгууллагын гадаад хамтын ажиллагаа хариуцсан 20 албан хаагч биетээр оролцсон ба цахимаар/Zoom/ мэдээлэл дамжуулж ЗТХЯ-ны бусад газар, хэлтсийн 30 гаруй албан хаагч хамрагдсан.<br>Сургалтаар зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй гадаад харилцаа, хамтын ажиллагаанд нэгдмэл бодлого чиглэл баримтлах, бодлого чиглэлийг хэрхэн уялдуулах талаар болон дипломат ёслол, гадаад хамтын ажиллагаанд баримтлан ажиллах ёс зүй, гадаадад болон дотоодод арга хэмжээ хэрхэн зохион байгуулах, анхаарах асуудлын талаар харилцан мэдээлэл авч, харилцан туршлага солилцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн ажил хэрэгч сургалт болсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3. Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн гадаад айлчлалаар хэлэлцэх асуудалд салбарын чиглэлээр санал хүргүүлж тусгуулах | Айлчлалаар хэлэлцэх асуудалд тусгасан саналын тоо | Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн 4 айлчлалд санал хүргүүлсэн. | Айлчлалын удирдамж, уулзалтын ярианы сэдэвт салбарын чиглэлээр 2 санал тусгагдсан байна. | Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн айлчлалаар хэлэлцэх асуудалд 4 санал тусгуулан ажилласан байна. Үүнд:<br>- Монгол Улсын ерөнхийлөгчийн Казахстан улсад зохион байгуулагдах ШХАБ-ын төрийн тэргүүн нарын уулзалтад оролцох албан ёсны айлчлал хийхтэй холбогдуулан БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүн нартай хийх уулзалтад монголын талаас баримтлах яриа хэлэлцээний сэдэвт зам, тээврийн салбарын чиглэлээр тусгах саналыг боловсруулж ГХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөх, эдгээр төлөвлөгөөнүүдийн биелэлтийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн ГХЯ-нд тус тус хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын Исламабад хотноо 2024 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд болох Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд ажиглагчаар оролцох үеэр баримтлах Үндсэн чиглэлд тусгах саналыг боловсруулж ГХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлэв.<br>- Монгол Улсын Засгийн газрын урилгаар БНХАУ-ын дэд дарга Хань Жэний 2024 оны 9 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлэв.<br>- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024 оны 11 дүгээр сарын эхээр Шанхай хотноо зохиогдох "Хятадын олон улсын импортын ЭКСПО"-д оролцож, БНХАУ-д ажлын айлчлалын үеэр хийх уулзалтын айлчлалын үндсэн чиглэл, ярианы сэдэвт тусгах санал боловсруулан хүргүүлэв. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Зам, тээврийн хөгжлийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэл хангах, албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зохион байгуулах | Айлчлал, гадаад томилолтын үйл ажиллагаа зохион байгуулсан тоо | Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын айлчлал 2 зохион байгуулагдсан. Яамны албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллуулах 10 тушаал шийдвэр гаргуулсан. | Арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан байх ба салбарын төлөөлөл хамрагдсан байна. Томилолтоор ажиллуулах шийдвэр гарч хэрэгжин тайлагнасан байна | -Зам, тээврийн сайдын БНХАУ-д хийсэн ***4 айлчлал*** бэлтгэл хангаж зохион байгуулан ажилласан.<br><br>-Яамны албан тушаалтан, албан хаагч, харьяа байгууллагын удирдлагын БНХАУ-д хурал зөвлөгөөн, сургалт, семинарт хамрагдсан ***нийт 23*** тушаал бэлтгэн, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн ажиллав.<br>/хурал, зөвлөгөөн-16 тушаал, сургалт семинар-7 тушаал/<br><br>1.ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлтийн БНХАУ-ын 2024.01.22-26-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотод /Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-рт оролцох/ чиглэлээр ажиллах тушаалын төсөл бэлтгэн, сайдаар батлуулав.<br>2.ЗТХЯ-ны ТНБД-ын 2024.02.26-03.01-ний өдрүүдэд БНАфрик улсад ажилласан. Ажлын бэлтгэл ажлыг хангаж ажиллав.<br>3. ЗТХ-ийн сайдын БНХАУ-ын ШУӨЗО-нд 2024.03.28-04.02-ны өдрүүдэд хийх ажлын | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласан.<br>4.ЗТХСайд С.Бямбацогтын БНХАУ-ын ШУӨЗО-нд хийх айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд ЗТХ-ийн сайдын зөвлөх И.Буянжаргал, ТЗУГ-ын дарга Ц.Одхүү, ИНБЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Лувсан-одсэр, ГХАХ-ийн мэргэжилтэн Л.Цолмон, Сайдын туслах П.Тамир, хэвлэл мэдээллийн ажилтан Э.Энхбат нарыг томилон ажиллуулах тушаалын төсөл бэлтгэн гаргуулав.<br>5. БНХАУ-д 2024.02.28-03.12-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Дэд бүтцийн холболтын дээд түвшний семинар" сэдэвт сургалтад хамрагдах зорилгоор БТГ-ын СССХ-ийн дарга Ц.Мядагмаа, АТБЗГ-ын ахлах шинжээч Ц.Санчирдорж, ХШҮДАГ-ын шинжээч Л.Шинэчимэг нарыг оролцуулах тушаал<br>6. БНХАУ-ын ӨМӨЗО-нд 2024.03.19-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захиргааны алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн нэгдүгээр улирлын уулзалт, хуралд оролцох зорилгоор АТБЗГ-ын ТЗБХ-ийн дарга Т.Мягмарсүрэнг томилон ажиллуулах тушаал<br>7. БНХАУ-ын Бээжин хотноо 2024.04.10-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Дэд бүтцийн төслийн санхүүжилт ба менежментийн семинар" сэдэвт сургалтад ТЗУГ-ын СХОХ-ийн ахлах мэргэжилтэн Ч.Очгэрэл, мэргэжилтэн Б.Одонтуяа, АТБЗГ-ын мэргэжилтэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Б.Батхорол нарыг оролцуулах тушаал<br>8. БНХАУ-ын Бээжин хотноо 2024.05.10-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Монгол Улсын төрийн удирдлагын семинар" сэдэвт сургалтад ТЗУГ-ын шинжээч П.Насанжаргал, мэргэжилтэн Т.Орхонтамир, АЗБЗГ-ын мэргэжилтэн Ж.Оюунжаргал, СХГ-ын ахлах мэргэжилтэн Ө.Мөнхзул, ХШҮДАГ-ын шинжээч Д.Баярмаа нарыг оролцуулах тушаал<br>9. БНХАУ/Хонгконг/-д зохион байгуулагдсан Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал" төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй сургалтад ТЗУГ-ын СХОХ-ийн дарга Н.Цэвэлмааг оролцуулах тушаал<br>10. БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан "Хөгжиж буй орнуудын ногоон хөгжил ба цэвэр эрчим хүчний менежментийн семинар" сэдэвт сургалтад АЗБЗГ-ын ахлах мэргэжилтэн Ц.Хосгэрэл, СХГ-ын ахлах мэргэжилтэн О.Чимгээ, ХШҮДАГ-ын шинжээч С.Түмэн-Өлзий, ИНБЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Лувсан-Одсэр, хэвлэл мэдээллийн ажилтан Г.Энхгэрэл нарыг оролцуулах тушаал<br>11. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод 2024.07.28-08.01-ний өдрүүдэд зохион байгуулагдах "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Хамтарсан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хорооны хурал"-д оролцох ТНБД С.Батболд, АТБЗГ-ын ТЗБХ-ийн дарга Т.Мягмарсүрэн нарыг оролцуулах тушаал<br>12. БНХАУ-ын Чэнду хотноо зохион байгуулагдах "Бүс ба зам" орнуудын шинэ эрчим хүчний хэрэглээ, хөгжил сэдэвт семинарт АЗБЗГ-ын ахлах мэргэжилтэн Х.Энэрэлсайхан, БТГ-ын мэргэжилтэн Б.Гүнхичээнгүй нарыг оролцуулах тушаал<br>13.БНХАУ-ын Тээврийн яам болон холбогдох байгууллагуудын удирдлагуудтай албан уулзалт хийх, тулгамдаж буй асуудлаар яриа хэлэлцээр хийх зорилгоор БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт нарыг томилолтоор ажиллуулах тушаал<br>14.БНХАУ-ын 2024.08.28-31-ний өдрүүдэд Эрээн өртөөнд автозам, төмөр замын боомтын үйл ажиллагаа, логистикийн терминалтай танилцах, тулгамдаж буй асуудлаар яриа хэлэлцээ хийх, шийдвэрлэх зорилгоор БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, АТБЗГ-ын дарга Э.Мөнхнасан, АТБЗГ-ын Ш.Хавидолда, ТЗДТБЗГ-ын газрын ахлах мэргэжилтэн Б.Батнасан нарыг томилолтоор ажиллуулах тушаал<br>15.БНХАУ-ын Бээжин хотноо 2024.09.05-06-ны өдрүүдэд БНХАУ-ын "Чайна энержи" компанитай хийх уулзалтад БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт нарыг томилолтоор ажиллуулах тушаал | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 16.БНХАУ-д зохион байгуулагдах НҮБ-ийн ивээл дор 2024.09.02-28-ны өдрүүдэд зохион байгуулж буй "Дэлхийн тогтвортой тээврийн дээд хэмжээний форум"-ын хүрээнд зохион байгуулагдах "Залуу манлайлагчдын хөтөлбөр" сждквт сургалтад ТЗУГ-ын ГХАХ-ийн мэргэжилтэн Л.Цолмонг оролцуулах тушаал<br>17. Зам, тээврийн сайдын БНХАУ-д 2024.09.23-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Дэлхийн тогтвортой тээврийн форум" арга хэмжээнд оролцох, ажлын айлчлалын бүрэлдэхүүнд БТГ-ын дарга Б.Артур, АТБЗГ-ын Э.Мөнхнасан, ТЗДТБЗГ-ын ТЗТХ-ийн дарга Д.Мөнхбат, ГХАХ-ийн дарга Б.Нямдаваа, ахлах шинжээч С.Үндрах, МТЗ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүх нарыг оролцуулах тушаал<br>18. БНХАУ-д 2024.09.22-29-ний өдрүүдэд зохион байгуулагдах "БНХАУ-ын Ляонин мужийн олон улсын 5 дахь удаагийн хөрөнгө оруулалт, худалдааны форум" арга хэмжээнд Далайн захиргааны ДАҮТОГ Б.Сайнбаярыг оролцуулах тушаал<br>19. БНХАУ-д 2024.09.22-29-ний өдрүүдэд зохион байгуулагдах "БНХАУ-ын Ляонин мужийн олон улсын 5 дахь удаагийн хөрөнгө оруулалт, худалдааны форум" арга хэмжээнд Далайн захиргааны ДАҮТОГ Б.Сайнбаярыг оролцуулах тушаал<br>20. БНХАУ-ын ҮХШХ, Хятадын төмөр замууд корпорацын холбогдох удирдлагуудтай уулзалт хийх БНАЛАУ-ын төмөр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | замтай танилцахаар БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, МТЗ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүх нарыг томилон ажиллуулах тушаал<br>21. МУ-ын Ерөнхий сайдын 2024.11.04-07-ны өдрүүдэд БНХАУ-д хийх айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд ЗТЯ-ны БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, ГХАХ-ийн дарга Б.Нямдаваа нарыг томилон ажлуулах тушаал<br>22. БНХАУ-д 2024.11.18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдах Олон улсын агаарын тээврийн холбооны Бээжин дэх Төлөөлөгчийн газартай уулзалт хийх, санамж бичиг байгуулахзорилгоор ИНЕГ-ын дарга Ч.Мөнхтуяаг томилон ажиллуулах тушаал<br>23. БНХАУ-ын Шанхай хотноо 2024.11.26-29-ний өдрүүдэд зохион байгуулахгдах "Баума Хятадын Шанхай олон улсын барилгын машин механизмын үзэсгэлэн"-д АЗБЗГ-ын дарга Ч.Сугармааг оролцуулах тушаал | | |
| 5 | Арга хэмжээ 1.5. Зам, тээврийн хөгжлийн сайдын БНХАУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах | Хэрэгжилтийн хувь | - | | 1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024.01.15-19-ний өдрүүдэд БНХАУ-ын Хэбэй, Шандун мужуудад хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллав. Үүнд:<br>-Айлчлалын тов тогтох тухай БНХАУ-ын Хэбэй, Шандун мужуудын Ардын засгийн ордонд хүргүүлэх бичиг боловсруулан ГХЯ-д хүргүүлсэн.<br>-ГХЯ-наас дэмжлэг хүссэн албан тоотыг боловсруулан хүргүүлэв.<br>-Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төсөл бэлтгэв. | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлаар яамдуудаас санал авах бичиг төлөвлөн ГХЯ, СЯ, ХЗДХЯаманд хүргүүлэв.<br>-Айлчлалын үеэр танилцуулах РРТ танилцуулгыг хятад хэлээр орчуулав.<br><br>2. ЗТХ-ийн сайдын БНХАУ-ын ШУӨЗО-нд 2024.03.28-04.02-ны өдрүүдэд хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Үүнд:<br>-Айлчлалын тов тогтох, төлөвлөгөө, хөтөлбөр гаргах чиглэлээр айлын талтай холбогдон ажилласан.<br>-Бизнес форум зохион байгуулахтай холбоотой оролцох аж ахуйн нэгжийн мэдээлэл, хөтөлбөр, илтгэл, үзэж танилцах үйлдвэрлэл технологийн паркын танилцуулга, мэдээллийг тус тус орчуулж бэлтгэв.<br>-Сайдын уулзалтын ярианы сэдэв бэлтгэв.<br>Айлчлалын үеэр танилцуулах илтгэл, танилцуулгыг монгол хэлнээс хятад хэлнээ орчуулж бэлтгэн ажиллав.<br>-Айлчлалын бүрэлдэхүүний нислэгийн тийз захиалж бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав.<br>3. Зам, тээврийн сайдын БНХАУ-ын Бээжин хотноо 2024.09.25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Дэлхийн тогтвортой тээврийн форум" арга хэмжээ болон Олон улсын тээврийн форумаас зохион байгуулах Азийн бүсийн 3 дахь дээд түвшний яриа хэлэлцээ арга хэмжээнд тус тус оролцох болон айлчлалын үеэр хийгдэх | | |

46

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Монгол Улсын Ерөнхий сайд Д.Оюун-эрдэнийн БНХАУ-ын Шанхай хотод 2024.11.04-07-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд Зам, тээврийн сайд, БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, ТЗУГ-ын ГХАХ-ийн дарга Б.Нямдаваа нар ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажиллав. | | |
| 6 | Арга хэмжээ 1.6. Гадаад улстай хийх Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зэрэг хамтын ажиллагааны уулзалтуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зэрэг 2 уулзалт хурал зохион байгуулж ажилласан. | | 1. Комиссын хуралдаан: Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын XVIII-р хуралдаан хугацаа болоогүй.<br>-Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг судлах хамтарсан ажлын хэсгийн хуралдааныг Монгол Улсад 2024.04.01-02-ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд БНХАУ-ын Улсын төмөр замын газартай харилцаж, хурлын урилга, хэлэлцэх асуудлыг тогтох, хөтөлбөр, төлөвлөгөө, протоколыг эцэслэх айлын талаас ирүүлсэн саналыг хятад хэлнээс монгол хэлрүү, монголын талын саналыг монгол хэлнээс хятад хэлрүү тус тус орчуулж Хятадын талтай холбож ажилласан. Мөн зочид төлөөлөгчдийг угтах, үдэх ажлын зохион байгуулах талд Хятадын талтай хамтран ажиллав.<br><br>2. Нийт 9 уулзалтын зохион байгуулалтыг бүрэн хангаж ажилласан. Үүнд:<br>Нийт<br>-ЗТХЯ-ны сайдын зөвлөх Д.Эрдэнэбат БНХАУ-ын | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ӨМӨЗО-ны Эрээн хотын улс төрийн зөвлөлийн дарга Чао гэ, засаг даргын 1-р орлогч дарга Жан Инжие тэргүүтэй төлөөлөгчидтэй 2024.01.23-ны өдөр хийсэн уулзалтын ярианы сэдэв бэлтгэн зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл сийрүүлж сайдын зөвлөхөд танилцуулав.<br>-Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайд Шэнь Минь Жуань тай 2024.03.15-ны өдөр хийсэн уудзалтын ярианы сэдэв бэлтгэв.<br>-Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт БНХАУ-ын ШУӨЗО-ны Цонж аймгийн Ардын засгийн газрын төлөөлөлтэй 2024.03.26-ны өдөр хийсэн уулзалтыг зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл сийрүүлж сайдад танилцуулав.<br>-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд БНХАУ-ын Ляонин Тянхэ группын ТУЗ-ын дарга Жао Юн гуо тэргүүтэй төлөөлөгчидтэй 2024.03.28-ны хийсэн уулзалтыг зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл сийрүүлэн ТНБД-д танилцуулав.<br>-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд БНХАУ-ын Бээжингийн зам харилцааны их сургуулийн багш нарын төлөөлөлтэй 2024.04.22-ны өдөр хийсэн уулзалтын ярианы сэдэв бэлтгэн, зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл сийрүүлэн ТНБД-д танилцуулав.<br>- Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт БНХАУ-ын Чиндао хотын ШХАБ-ын хамтын ажиллагааны байгууллагын орон нутгийн эдийн засаг, худалдааны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтын ажиллагааны бүсийн нарийн бичгийн дарга Жан Шинжу тэргүүтэй төлөөлөгчидтэй 2024.05.14-ны өдөр хийсэн уулзалтын ярианы сэдэв бэлтгэн зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлийг сийрүүлэн Сайдад танилцуулав.<br>-Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Шэнь Минь Жуаньтай хийсэн уулзалт<br>-Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан 2024.08.12-ны өдөр БНХАУ-ын Ляонин мужийн дэд захирагч Жин Гуовэйтэй хийсэн уулзалт<br>-Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан 2024.11.11-ний өдөр БНХАУ-ын Хятадын төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний корпорац(CRRC)-ийн ажлын хэсгийн төлөөлөлтэй хийсэн уулзалт | | |
| **Зорилт 2. Гадаад улс, олон улсын байгууллагуудтай зам, тээврийн салбарын чиглэлээр байгуулах хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийг байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах, бүх талын дэмжлэг үзүүлнэ.** | | | | | | | |
| | Арга хэмжээ 2.1. Гадаад улс, олон улсын байгууллагуудтай хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийг байгуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах | Боловсруулсан баримт бичгийн тоо<br><br>Хянаж, дэмжлэг үзүүлсэн баримт бичгийн тоо | Гадаад улстай<br>1 Протокол, 2 Санамж бичиг байгуулсан.<br>3 баримт бичгийн төсөлд санал хүргүүлсэн. | 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хоёр талын болон олон талт хэлэлцээр болон бусад баримт бичиг байгуулах ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлсэн байна.<br><br>Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн орчуулга хянаж дэмжлэг үзүүлсэн байна.<br><br>Гадаад улсад явуулах албан бичиг болон гадаад улсаас | 1. Хэлэлцээр, санамж бичгийн орчуулга:<br>-Монгол-БНХАУ-ын Засгийн газар хоорондын хилийн төмөр замын хэлэлцээрийн шинэчилсэн төсөл<br>-Хятадын талаас 2024,01.05-ны өдөр ирүүлсэн саналыг орчуулж ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.<br>- Монголын талын хэлэлцээрийн төсөлд оруулсан өөрчлөн найруулга, нэмэлт өөрчлөлтийг орчуулж 2024,01,16-ны өдөр цахимаар БНХАУ-ын төмөр замын газарт хүргүүлсэн.<br>-Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн Газар хоорондын Хятад-Европ (ази) | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ирсэн албан бичгийн орчуулга хянаж дэмжлэг үзүүлсэн байна. | чиглэлийн галт тэрэгний хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх санамж бичиг төслийг хятад хэлнээс монгол хэлнээ орчуулав.<br><br>2. Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, хэлэлцээр байгуулахтай холбоотой БНХАУ-ын холбогдох байгууллагад явуулах албан бичгийн орчуулга хийж айлын талд цахимаар хүргүүлж, айлын талаас ирсэн хариу албан тоотыг орчуулж удирдлага, холбогдох газарт хүргүүлж ажилласан. Үүнд:<br><br>-ТЗДТБЗГ-аас БНХАУ-ын Тээврийн яамны дэд сайдад 2024.01.23-ны өдөр явуулсан албан бичгийг оруулж хүргүүлэв.<br>-АТБЗГ-аас -аас БНХАУ-ын Тээврийн яамны Тээврийн үйлчилгээний газарт хүргүүлэх бичгийг 2024.01.26-ны өдөр орчуулж Хятадын тээврийн яамны Гадаад хамтын ажиллагааны мэргэжилтэн Xiao Yao -д хүргүүлсэн.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газраас 2024.03.14-ний өдөр ирүүлсэн албан бичгийг орчуулж ТЗДТБЗГ-т хүргүүлэв.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газрын дарга Ан Лушенд явуулах 2024.03.15-ны өдрийн 02/65 тоотыг орчуулав.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газраас ирүүлсэн нэгдсэн төлөвлөгөөг хятад хэлнээс орчуулж ТЗДТБЗГ-т өгөв.<br>-АТБЗГ-аас -аас БНХАУ-ын Тээврийн яамны дэд сайд Ли Янгд явуулах албан тоотыг 2024.04.12-ны өдөр орчуулж Хятадын тээврийн яамны Гадаад хамтын ажиллагааны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалтуудын бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав. Үүнд:<br>- Айлчлалын тов тогтох, төлөвлөгөө, хөтөлбөр гаргах чиглэлээр айлын талтай холбогдон ажилласан<br>- Сайдын уулзалтын ярианы сэдэв, хуралд тавих илтгэл, танилцуулгыг монгол хэлнээс хятад хэлнээ орчуулж бэлтгэн ажиллав.<br>-Айлчлалын бүрэлдэхүүний нислэгийн тийз, зочид буудал захиалах, хуралд бүртгүүлэх, оролцох бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав.<br>Мөн айлчлалын үеэр хоёр талт уулзалтуудыг зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав. Үүнд:<br>-БНХАУ-ын Тээврийн сайд Ли Шяопэнтэй 2024.09.24-ний өдөр хийсэн хоёр талт уулзалт;<br>-ОХУ-ын Тээврийн яамны орлогч сайд В.В.Потешкин, БНСВУ-ын Тээврийн сайд Нгуен Ван Тангтай 2024.09.25-ны өдөр хийсэн уулзалт;<br>-"Хятадын төмөр замын групп" компанийн ТУЗ-ын дарга Лю Жэнфантай 2024.09.24-ний өдөр хийсэн уулзалт;<br>-Хятадын төмөр замын инженеринг корпорац (CREC)-ийн удирдлага Рэн Хунпэнь 2024.09.23-ны өдөр хийсэн уулзалт;<br>Хятадын төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний корпорац (CRRC)-ийн ТУЗ-ын дарга Сүн Юнцайтай 2024.09.27-ний өдөр хийсэн уулзалт;<br>-"Чайна энержи групп" компанийн удирдлагуудтай 2024.09.27-ний өдөр хийсэн уулзалт; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжилтэн Xiao Yao -д хүргүүлсэн.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газрын газрын даргад явуулах 2024.05.10-ны өдрийн албан тоотыг орчуулав.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газрын дарга Фэй Дун Бин-д 2024.06.13-ны өдөр явуулсан албан тоотын орчуулга<br>- Монгол-БНХАУ-ОХУ-ын эдийн засгийн коридорын ажлын хэсгийн хурал Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан хурлын төлөвлөгөө, хөтөлбөр, нэрс, протоколын төсөл, хятад-монгол-хятад орчуулга хийв.<br>-БНХАУ-ын Тээврийн яамны үйлчилгээний газрын дарга Цай Туанжед явуулах 2024.08.10-ны өдрийн албан тоотын орчуулга хийв.<br>- БНХАУ-ын Тээврийн сайд Ли Шяаопэнд 2024.09.13-ны өдөр явуулсан албан тоотын орчуулга<br>- БНХАУ-ын Тээврийн яаманд 2024.09,30-ны өдөр явуулсан албан тоотын орчуулга хийв.<br>-БНХАУ-ын Хятадын төмөр замууд корпорацийн олон улсын хэлтсийн дарга Жү ГуоЖианд явуулсан албан тоотын орчуулга хянан засварлав.<br>-БНХАУ-ын Хятадын төмөр замууд корпорацын ТУЗ-ын дарга Чэн юн-д 2024,09,22-ны өдөр явуулсан албан тоотын орчуулга хийв.<br>-БНХАУ-ын Улсын төмөр замын газрын орлогч дарга Ан Лушенд 2024.10.14, 2024.11.21. 2024.11.29-ний өдөр явуулсан албан тоотын орчуулга тус тус хийв.<br>- БНХАУ-ын Тээврийн сайд Лю Вэйд 2024.11.19-ний өдөр | | |

52

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | явуулсан албан тоотын орчуулга хийв.<br><br>-Мөн ЗТХЯ-д хандаж БНХАУ-аас цахимаар болон шуудангаар ирсэн нийт 7 албан бичгийн орчуулга хийв. | | |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Авлигын эсрэг хуульд заасны дагуу 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг заасан хугацаанд нь гаргаж тайлагнах | Хэрэгжилтийн хувь | 2022 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж тайлагнасан | 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн гаргаж, тайлагнасан байна.<br>Их хэмжээний өөрчлөлт орсон тохиолдолд мэдэгдэнэ. | Авлигийн эсрэг хуульд заасны дагуу 2023 оны хөрөнгө оролгын мэдүүлгийг заасан хугацаанд нь гаргаж тайлагнасан | I- IV улирал | |
| 2. | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | - | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан байна. | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан. | I- IV улирал | |
| 3 | Нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан тайлагнах | Нэгжийн 2023 оны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв гаргаж үнэлүүлсэн байна. | - | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах<br>Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж удирдлагад танилцуулан үнэлүүлнэ. | -ГХАХ-ийн 2024 оны нэгжийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, жилийн эцсээр нэгтгэн гаргасан.<br>-Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг ТЗУГ-т хүргүүлсэн.<br>-Гадаад арга хэмжээний 2024 оны тайлан гаргав. | I- IV улирал | |
| 4 | Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээх | Нийгмийн сүлжээгээр дамжуулан түгээсэн мэдээ, мэдээллийн тоо, давтамж | - | Нийгмийн сүлжээгээр дамжуулан түгээсэн мэдээ, мэдээллийн тоо, давтамж нэмэгдсэн байна. | Фэйсбүүк хуудсаар дамжуулан зам, тээврийн салбарын мэдээ, мэдээллийг түгээн ажилласан. | I- IV улирал | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Зам, тээврийн хөгжлийн яамны гадаад арга хэмжээний чиглэлээр авч | Хэрэгжилтийн хувь | - | Хуулиар заасан хугацаанд тайлан | Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлсэн ажлын тайлан, төлөвлөгөөг Гадаад харилцааны яаманд хүргүүлэх | | | төлөвлөгөөг хүргүүлсэн байна. | журам"-д заасны дагуу тус яамны зүгээс 2023 онд гадаад арга хэмжээний чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>2024 онд гадаад арга хэмжээний чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. | | |
| 2 | Арга хэмжээ 2. Зам, тээврийн хөгжлийн сайдын урилгаар ХБНГУ-ын Холбооны Цахим хөгжил, тээврийн сайд, Бундестагийн гишүүн, ноён Др. Фолькер Виссингийн 2024 оны 03 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийх албан ёсны айлчлал зохион байгуулах | Арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан байна. | - | Зочин төлөөлөгчдийн айлчлалын бэлтгэл хангагдаж, арга хэмжээ зохион байгуулагдсан байна | Зам, тээврийн хөгжлийн сайдын урилгаар ХБНГУ-ын Холбооны Цахим хөгжил, тээврийн сайд, Бундестагийн гишүүн, ноён Др. Фолькер Виссингийн 2024 оны 03 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийх албан ёсны айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- Айлчлалын бүрэлдэхүүнийг нисэх онгоцны буудал дээр угтах, үдэхтэй холбоотой ажлыг зохион байгуулав.<br>-2024.03.05-ны өдрийн 15.30-17.30 цагт Төрийн ордны жанжин Д.Сүхбаатар танхимд зохион байгуулах өргөтгөсөн уулзалт, санамж бичиг зурах ёслол, хэвлэлийн бага хурал зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд уулзалтын бүрэлдэхүүн тогтох, гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдийг ордонд оруулах бэлтгэл ажлыг хангаж, ярианы сэдэв, танилцуулга бэлтгэн, гарын үсэг зурах санамж бичиг ГХЯ-аар хянуулж бэлэн болгосон. Мөн хэвлэлийн бага хурал зохион байгуулах бэлтгэл ажил хангаж хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж зохион байгуулав.<br>-2024.03.07-ны өдөр Зочид төлөөлөгчдийг Монгол уламжлалт ахуйтай танилцуулах арга хэмжээг "Чингисийн хүрээ"-нд жуулчны баазад зохион байгуулав.<br>-2024.03.08-нд зочид төлөөлөгчдийг үдэх ажиллагаар зохион байгуулав. | I- IV улирал | |
| 3 | Арга хэмжээ 3. Их Түмэн санаачилгын "Тээврийн зөвлөлийн 13 дугаар хурал"-ыг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр | Арга хэмжээ амжилттай зохион | - | Зочин төлөөлөгчдийн айлчлалын | Их Түмэн санаачилгын "Тээврийн зөвлөлийн 13 дугаар хурал"-ыг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Гадаад | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулав. . | байгуулагдсан байна. | | бэлтгэл хангагдаж, арга хэмжээ зохион байгуулагдсан байна | харилцааны яамны "Зөвшилцөл" танхимд зохион байгуулав. Хурлын зочид төлөөлөгчдийн хурлын хөтөлбөрийн дагуу арга хэмжээнд хамруулах зохион байгуулалтад оролцож ажиллав. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Мэргэжил, ур чадварын түвшин дээшилсэн байна | - | Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | | I- IV улирал | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших | Мэргэжил, ур чадварын түвшин дээшилсэн байна | - | Зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмшсэн байна. | 1.Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид болон харьяа байгууллагуудын гадаад харилцааны асуудал хариуцсан албан хаагчдын сургалт, семинар"-ыг 2024 оны 05 сарын 07-ны өдөр хамрагдав.<br>2. Монгол бичгийн дунд хугацааны сургалтад 2024.10.08-11.27 өдрүүдэд хамрагдав. | I- IV улирал | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ

............................ / С.Үндрах/ ................

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

55